

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/02.

Арвайхээр сум

Эрүүл мэндийн газрын дотоод хяналт,
шалгалтыг зохион байгуулах журам, багийн
бүрэлдэхүүн шинэчлэн батлах тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,1 дэхь заалт, Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5, 1.6 дахь заалт, Засаг даргын 2012 оны дугаар сарын 13-ны өдрийн а/84 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын дотоод хяналт шалгалтын багийн бүрэлдэхүүн нэгдүгээр, журам"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Байгууллагын дотоод хяналт, шалгалтын ажлыг төлөвлөгөө, удирдамжийн дагуу зохион байгуулж, хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилд байгууллагын удирдлагад тайлагнахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн даргад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийг газрын даргын 2012 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 69 дүгээр, 2019 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А/25 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д. ШИВААННҮРДЭВ

622301003

My Doc.tushaa/EMG/

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
01 дүгээр сарын 15 - ны өдрийн 4102 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Багийн ахлагч:

Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн хууль, эрх зүйн мэргэжилтэн

Гишүүд:

Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт
сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн

Эмнэлгийн тусламжийн хэлтсийн хүүхдийн тусламж үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн

Хяналт шинжилгээ үнэлгээ, мэдээллийн хэлтсийн мэдээлэл, технологи,
телемедицин хариуцсан мэргэжилтэн

Захиргаа санхүү нийтлэг үйлчилгээний албаны үйлчлэгч

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны
01 дүгээр сарын 15 ны өдрийн 4/02 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Зорилго нь: Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд дотоод хяналтын чиглэлээр шалгалтыг хийж, албан хаагчид хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах, ил тод, шударга үнэнч, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ажлын цаг ашиглалт, бүтээмж, санаачилга, хариуцлага, сахилга дэг журам, ажлын чиг үүргийн хүрээнд ёс зүйтэй, эрх тэгш байдлыг эрхэмлэх, алдаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах, дахин гарахаас сэргийлэх чиглэлээр дотоод хяналт зохион байгуулахад чиглэгдэнэ.

Нэг. Дотоод хяналт шалгалтын зарчим

- 1.1. Багийн бүрэлдэхүүн нь хяналт шалгалт явуулахдаа холбогдох хууль, эрх зүйг баримтлаж, тухайн үйл ажиллагааны бодит нөхцөл байдлыг хуулийн дагуу шударга, үнэн судалж, бусдаас хараат бус, хөндлөнгийн нөлөөнд автахгүй, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх зарчмыг баримтлана.
- 1.2. Илэрсэн алдаа, зөрчлийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрт нийцүүлэн арилгуулах арга хэмжээ авна.

Хоёр. Хамрах хүрээ

- 2.1. Эрүүл мэндийн газрын хэлтэс, албадын албан хаагчид хамрагдана.

Гурав. Дотоод хяналт шалгалт хийх үйл ажиллагааны чиглэл

- 3.1. Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт хамгаалалт, зарцуулалтад
- 3.2. Байгууллагын гадаад, дотоод орчны эрүүл ахуй ариун цэвэр, хөдөлмөрийн аюулгүй байдал, учирч болзошгүй эрсдэлт хүчин зүйлд,
- 3.3. Албан хаагчдын ажлын цаг ашиглалт, бүртгэлд хяналт шалгалт, тандалт судалгаа,
- 3.4. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд

Дөрөв. Дотоод хяналт шалгалт зохион байгуулах ажлын багийн бүрэлдэхүүний эрх, үүрэг

Багийн бүрэлдэхүүний эрх:

- 4.1. Багийн бүрэлдэхүүн дотоод хяналт шалгалтын чиглэлийн сургалтад хамрагдаж, мэдлэг, чадвараа нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

4.2.Хяналт шалгалт хийхдээ холбогдох албан тушаалтнаас шаардлагатай баримт бичгийг гаргуулна.

4.3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд төлөвлөгөөт болон гэнэтийн хяналт шалгалт хийнэ.

4.4.Шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авах, хамтран ажиллаж болно.

Багийн бүрэлдэхүүний үүрэг:

4.5. Холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг мөрдөж ажиллана.

4.6.Дотоод хяналт, шалгалтын ажлын хэсэг жил бүр төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийн үр дүнг тооцох, хийсэн ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, байгууллагын удирдлагад тайлагнах, хамт олонд мэдээлэл хүргэнэ.

4.7.Байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд хөрөнгийн хэрэглэж ашигласан хугацаа, хэрэглээний шаардлагад нийцсэн эсэхийг үнэлж тулгуурлан, байгууллагын хөрөнгийн тооллогын жагсаалт, бүртгэлд бичигдсэн үнийн дүнгээр хохирлыг үнэлсэн байна.

4.8.Хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил нь тухайн албан хаагч засч болох, байгууллагад болон бусдад гэм хор учруулаагүй, санамсаргүй хайхрамжгүй байдлаар үйлдэгдсэн бол цаашид алдааг гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.

4.9.Байгууллагын албан хаагчаас дээрх үйл ажиллагааны чиглэлд хамрагдах гомдлыг хүлээн авч, байгууллагын удирдлагад танилцуулан, нөхцөл байдлыг судлан, шийдвэрлүүлэх арга хэмжээ авч, хариу хүргүүлэх. Дотоод хяналт шалгалтын чиглэлд хамрахгүй өргөдөл, гомдлийн хүлээн авахгүй байж болно.

4.10. Хөндлөнгийн нөлөөд автахгүй байна.Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллана.

Тав.Байгууллагын албан хаагчдын эрх, үүрэг

5.1.Албан хаагчдын эрх:

Байгууллагын дотоод хяналт шалгалт хийх үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд өргөдөл,гомдол санал хүсэлт гаргах эрхтэй.

5.2.Хяналт шалгалтын тйалантай танилцах, илэрсэн алдаа зөрчлийн талаар мэдээлэл авч болно.

5.3.Албан хаагчдын үүрэг:

Хяналт шалгалт хийхэд шаардлагатай баримт бичгийг гаргаж өгөх /Тайлан, судалгаа, мэдээлэл, бусад/

Зургаа. Хариуцлага

6.1.Дотоод хяналт шалгалтаар алдаа зөрчил илэрсэн тохиолдолд байгууллагын эд хөрөнгийн хохирлыг барагдуулах, дахин гаргуулахгүй байх, хуулийн дагуу хариуцлага

тооцож ажиллах саналыг байгууллагын удирдлагад хүргүүлэн, шийдвэрлүүлж, шийдвэрийн дагуу тухайн албан хаагчид хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Албан хаагч дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг албан хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсэх, эсвэл эд хөрөнгөд санаатай хохирол учруулсан, бусдад худалдах сэдэл гаргасан, худалдсан зэрэг гэмт хэргийн шинжтэй бол хуулийн байгууллагад хандаж шийдвэрлүүлнэ.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БАГ